



Э-Сонин

20 дэх дугаар

2013 он • 12 сар



Монголын
Хөрөнгийн Бирж
2013 онд

Монголын хөрөнгийн биржийн 2013
оны онцлох



Санхүүгийн зохицуулах хорооноос
гаргасан шийдвэрүүд

“Бэрэн майнинг” ХК үнэт цаасаа
анхдагч зах зээл дээр санал
болгохоор сурталчилгаагаа
эхлүүлээ



“МЕРЕКС” ХХК-н нийтэд санал болгон
гаргах үнэт цаасыг СЗХ бүртгэсэн байна

“Дархан хүнс” ХК-ийн хувьцаа
эзэмшигчдын анхааралд



МХБ онлайнаар болон утсаар иргэн, албан
байгууллагын санал хүсэлт өргөдөл
гомдлыг хүлээн авдаг боллоо

Үйл явдал

- Монголын Хөрөнгийн Бирж 2013 онд
- Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрүүд
- “Бэрэн майнинг” ХК үнэт цаасаа анхдагч зах зээл дээр санал болгохоор сурталчилгаагаа эхэллээ
- “МЕРЕКС” ХХК-н нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг СЗХ бүртгэсэн байна
- “Дархан хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдын анхааралд
- МХБ онлайнаар болон утсаар иргэн, албан байгууллагын санал хүсэлт өргөдөл гомдлыг хүлээн авдаг боллоо

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 12-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

- Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох сургалт 1-р сарын 6-ны өдөр эхэлнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг
Утас: 11-313747
www.mse.mn



Монголын Хөрөнгийн Бирж

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН 2013 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

- ◆ Бүртгэлтэй ХК **261**
- ◆ Гишүүн БДК **79**
- ◆ Нийт арилжаа **98,5** тэрбум төг
- ◆ Зах зээлийн үнэлгээ **1,6** их наяд төг, сүүлийн хагас жилийн үзүүлэлтээр 13,5%-иар өссөн байна.
- ◆ ТОП-20 индекс **16,301.81** нэгж, сүүлийн хагас жилийн үзүүлэлтээр 13,2%-иар өссөн байна.
- ◆ “Бэрэн майнинг”, “Мерекс” ХК-иудын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэж, тус ХК-иудын хувьцааг анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгон арилжаалах бэлтгэл ажлыг хангаад байна.

- ◆ “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Уг хууль нь 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх бөгөөд Хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажлыг үр дүнтэй болгох, дотоодын болон олон улсын хөрөнгө оруулалтыг татах, орчин үеийн санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгох, бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх цаашлаад дотоод, гадаадын хөрөнгийн бирж дээр үнэт цаасыг давхар бүртгэх ажлыг зохион байгуулах чиглэлээр УИХ, Засгийн газрын зүгээс бодлогын түвшинд хэлэлцэж ирсэн санаачилгууд ийнхүү биеллээ олох боломж бүрдээд байна.
- ◆ Хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажлын хүрээнд Брокер дилерийн компаниуд өөрийн ажлын байрнаас буюу алсаас үнэт цаасны арилжаанд оролцож эхэллээ.
- ◆ УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Хөрөнгө оруулалтын сангийн тухай” хуулийг батлууллаа. Энэхүү хуулийг мөн 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөх бөгөөд тус хуулиар хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд чухал ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын сангуудыг үүсгэн байгуулах, шууд бус хөрөнгө оруулалтыг дэмжих механизмыг бий болгож байна.
- ◆ Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE групптэй Санхүүгийн индекс боловсруулан тооцоолох чиглэлээр хамтран ажиллах гэрээг байгуулсан. Зах зээлийн хөдөлгөөнийг зөв хэмжих, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, дотоодын зах зээлд татан оролцуулах олон улсын жишиг индексийн тооцоололтой болох юм.
- ◆ Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE-ийн “Хөгжиж буй” (Frontier Market) зах зээлийн зэрэглэлд оруулахаар “Ажиглалтын жагсаалт”-нд багтаасан байна. “Хөгжиж буй” зах зээлийн зэрэглэлтэй болох нь манай хөрөнгийн зах зээлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчдыг татах, үсрэнгүй хөгжиж буй салбаруудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг харьцангуй урт хугацаанд өртөг багатай санхүүгийн эх үүсвэрээр хангах боломж бий болно.
- ◆ Дэлхийн санхүүгийн төвүүд болох Нью-Йорк, Лондон, Хонконг, Сингапур хотуудад олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай хөрөнгө оруулалтын талаар сурталчилгаа уулзалтуудыг зохион байгуулж, дотоодын зах зээл болон шинэчилсэн хууль эрх зүйн орчны талаар сурталчилан хамтран ажиллах ажлыг эхлүүлээ.

ЭРХЭМ ХАРИЛЦАГЧ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИД ТА БҮХЭНД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ХАМТ ОЛНООС ШИНЭ ЖИЛИЙН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ЯПОН УЛСЫН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АГЕНТЛАГТАЙ УРТ ХУГАЦААНД ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны 9 хүний бүрэлдхүүнтэй баг Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний агентлагаас зохион байгуулсан тусгайлсан сургалтад 2013 оны 11 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд амжилттай хамрагдлаа. Уг сургалтын хүрээнд Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг, Үнэт цаас ба хөрөнгийн биржийн хяналтын хороо /

SESC/, Японы хөрөнгийн бирж групп /JPX/, Токиогийн таваарын бирж /TOCOM/-ийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судлах, холбогдох удирдлагуудтай нь албан уулзалт хийж, цаашдын урт хугацааны хамтын үйл ажиллагааны суурийг тавих үндсэн зорилтыг агуулсан болно.

Уг семинарын хүрээнд СЗХ-ны төлөөлөгчид тусгайлсан сургалтын хөтөлбөрт хамрагдсанаас гадна тэдгээрийг Японы Санхүүгийн үйлчилгээний агентлагийн дарга ноён Р.Хатанака хүлээн авч уулзсан бөгөөд ноён Р.Хатанака болон СЗХ-ны дэд дарга Б.Даажамба нар ойрын хугацаанд хоёр байгууллагын хамтын ажиллагааны санамж бичиг зурахаар тохиролцоонд хүрсэн нь хоёр байгууллагын хамтрах үйл ажиллагааны эхлэлийг амжилттай тавьж, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх бололцоог нээж өглөө. Мөн Санхүүгийн үйлчилгээний агентлагийн зүгээс СЗХ-г Олон улсын үнэт цаасны хороодын байгууллага /IOSCO/-ын идэвхит гишүүнээр элсэхэд өөрийн зүгээс дэмжихээр боллоо.



**МХБ ОНЛАЙН БОЛОН УТСААР
ИРГЭН, АЛБАН БАЙГУУЛЛАГЫН
САНАЛ ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН
АВДАГ БОЛЛОО**

Та Монголын хөрөнгийн биржийн 11-323715 дугаарын утсаар холбогдож, 2 дугаарыг дарж Хяналтын албатай холбогдох, эсхүл Вэбсайтын баруун дээд хэсэгт байрлах “Санал, гомдол” холбоосоор орж харгалзах маягтын дагуу өөрийн санал хүсэлт, өргөдөл гомдолоо бидэнд *feedback@mse.mn* хаягаар ирүүлнэ үү.



**“ДАРХАН ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЫН АНХААРАЛД**

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 11-р сарын 06-ны өдрийн 414 тоот тогтоолоор “Дархан Хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Батнасан, Д.Бат-Эрдэнэ, Б.Одонцэцэг, С.Оюунчимэг, Б.Бат-Өлзий нараас тус компанид олгосон нийт 615,213,981 / зургаан зуун арван таван сая хоёр зуун арван гурван мянга есөн зуун наян нэг / төгрөгийн зээлийн өрөнд тус бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 239 943 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргах, өмчлөх эрхийг баталгаажуулахыг зөвшөөрсөн байна.

Компани нь хаалттай хүрээнд үнэт цаас нэмж гаргасантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй болон хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчдэд Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн болохыг энэхүү мэдэгдлээр мэдэгдэж байна.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД

Санхүүгийн зохицуулах хороо, 2013 оны 12 дугаар сард Үнэт цаасны зохицуулалтын хүрээнд дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

Үүнд:

- ◆ “Шинэст” ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээв.
- ◆ “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 6.1.3, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.4, Аж аухйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, СЗХ-ны “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.12, 8.1.3, 8.1.6 дэх заалтуудыг тус тус үндэслэн СЗХ-ны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 502, 503, 504 тоот тогтоолоор “Би би эс эс”, “Монхан трейд”, “Тэнгри секуритиес” ХХК-иудын үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлжээ. Дээрх хугацаанд хорооноос өгсөн үүрэг даалгавар, албан шаардлагын биелэлтэд гаргасан зөрчил, дутагдлаа арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг анхаарууллаа.
- ◆ “Эс Жи Капитал” ХХК-ийн брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгав.
- ◆ “Тень Ди Сек”, “Бага хээр”, “НИКИ”, “Юу Жи Эс” ХХК, “Санхүүгийн хөгжил инвест”, “Очир-Эрдэнэ инвест” ХХК-иудын брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлжээ.
- ◆ “Грийт секьюритис” ХХК-ийн брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлжээ.
- ◆ “Ханш инвест” ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болсон байна.

Монгол Улс,
Улаанбаатар хот 15160,
Чингэлтэй Дүүрэг, Бага
тойруу 3, Засгийн
Газрын IV байр.
Санхүүгийн зохицуулах
хороо

<https://www.frc.mn>



**“БЭРЭН МАЙНИНГ” ХК ҮНЭТ ЦААСАА АНХДАГЧ
ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНАЛ БОЛГОХООР
СУРТАЛЧИЛГААГАА ЭХЭЛЛЭЭ**

“Бэрэн майнинг” ХК нь анх 2006 онд “Бэрэн групп” ХХК-ийн охин компани болон байгуулагдаж Монгол Улсын хар төмөрлөгийн салбарт үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Энэ ажлын хүрээнд Архангай аймгийн Төвшрүүлэх суманд байрших “Тамирын гол”-ын төмрийн хүдрийн ордын ашиглалтын асуудлыг хариуцаж жилдээ 250 мян.тн 63-67%-ийн төмрийн агуулгатай хүдрийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай уулын баяжуулах үйлдвэрийг 2007 онд ашиглалтанд оруулсан.

Үнэт цаас гаргагч нь Архангай аймагт орших 4 ордыг зэрэг эзэмшдэг бөгөөд ордуудын нийлбэр нөөц нь 84.6 сая.тн байна.

“Бэрэн майнинг” ХК нь уг нөөцийг цаашид үр ашигтай ашиглах үүднээс одоогийн 250 мян.тн-ны төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг 500 мян.тн болгож үүнээс 300 мян.тн шууд ангижруулсан төмөр үйлдвэрлэх үйлдвэр байгуулахаар Монголын хөрөнгийн зах зээл дээр компанийнхаа нийт хувьцааны 30 хувь буюу 522,243,996 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож байна.

Хувьцааны захиалгыг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй брокер, дилерийн компаниудаар авах бөгөөд Үнэт цаасны дэлгэрэнгүй болон хураангуй танилцуулгыг www.frc.mn, www.mse.mn, www.beren.mn, www.bdsec.mn зэрэг цахим хаягуудаас гадна андеррайтер “БиДиСЕК” ХК-иас авах боломжтой.

Олон нийтэд санал болгох:

Үнэ:	250 төгрөг
Үнэт цаасны тоо, ширхэг:	522 243 996
Хувь:	30%
Арга:	Тогтоосон үнийн

Нэрлэсэн үнэ: 157.35 төгрөг

Үнэт цаасны танилцуулгыг [энд дарж](#) үзнэ үү.

**“ШАРЫН ГОЛ” ХК-Н ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛЫН ОРЛОГЧ Б.БАТБААТАР
ТОМИЛОГДЛОО**



2010 оноос “Шарын гол” ХК (MSE:SHG)-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа Б.Батбаатарыг ТУЗ-ийн **SHARYN GOL JSC** шийдвэрээр тус компаний гүйцэтгэх захирлын орлогчоор томилжээ. “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Батмөнх, компанийнхаа ирээдүйн зорилт болох Монгол орны хойд бүсийн хэрэглэгчдийг нүүрсээр хангагч голлох үйлдвэрлэгч компани болох байр сууриа бэхжүүлэхэд шинээр томилогдсон гүйцэтгэх захирлын орлогчийн мэдлэг, туршлага, ур чадвар чухал нөлөө үзүүлнэ хэмээн найдаж байгаагаар илэрхийлсэн байна.

**“МЕРЕКС” ХХК-Н НИЙТЭД САНАЛ БОЛГОН
ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ СЗХ БҮРТГЭЖЭЭ**

“Мерекс” ХХК зохион байгуулалтын хэлбэрээр өөрчлөн нээлттэй Хувьцаат компани болж байгаатай холбогдуулан тус компанийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 65,005,000 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай асуудлыг Санхүүгийн зохицуулах хороо 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж зөвшөөрсөн байна.

“Мерекс” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны 514 дүгээр тогтоолыг [энд дарж](#) үзнэ үү.



Сарын арилжааны мэдээ


2013 оны 12 дугаар сар

Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	1 273 071
Нийт үнийн дүн	3 270 828 440
Хэлцлийн тоо	1 857
Арилжигдсан үнэт цаасны тоо	86
Зах зээлийн үнэлгээ	1 670 531 200 066.38

ТОП-20 индекс

Хаалт	16 301.81
Өмнөх хаалт	15 301.3
Өөрчлөлт /төг/	-16 301.81
Өөрчлөлт /%/	93.86
52 долоо хоног дээд	18 301.9
доод	13 188,46



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:					Үнийн дүнгээр:				
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	RMC	РЕМИКОН	356 243	60 122 064	1	DZG	ДАРХАН ЗБ	71 093	1 800 074 760
2	BDS	БИДИСЕК	309 889	595 446 130	2	BDS	БИДИСЕК	309 889	595 446 130
3	HGN	ХӨХ ГАН	89 903	11 590 775.24	3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	43 795	243 163 285
4	DHL	СЭЛЭНГЭ ДУЛААНХААН	76 440	7 644 000	4	APU	АПУ	19 596	78 606 656
5	HBO	ХАЙ БИ ОЙЛ	74 067	25 198 900	5	RMC	РЕМИКОН	356 243	60 122 064

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх өдрийн хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төг	%
1	HSR	ХАСУ МАНДАЛ	1 800	2 645	0	46.9
2	TTL	ТАВАН ТОЛГОЙ	4 292	6 055	845	41.08
3	MNH	МОНГОЛ НЭХМЭЛ	4 697	6 200	1 763	32
4	NXE	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	2 620	3399	1 503	29.7
5	ATI	АГРОТЕХИМПЕКС	1 100	1 400	779	27.3

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх өдрийн хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төг	%
1	UBH	УЛААНБААТАР ХИВС	14 880	11 000	0	-26.07
2	DAR	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	991	770	-3 880	-22.3
3	NIE	НОЁТ ХАЙРХАН	1 996	1 600	-221	-19.8
4	SOR	СОР	1 894	1 600	-396	-15.5
5	HAM	ЦАГДУУЛТАЙ	5 960	5 070	-294	-14.9